



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/339

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох, эрх сэргээх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 10.1.4, 10.1.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, 19.21, 19.22, 19.23 дахь хэсэг, Эрүүл мэндийн яамны "Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс"-ын 2019 оны 06 дүгээр сарын 12-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр олгох байгууллагын нэрсийг нэгдүгээр, эрх сэргээх байгууллагын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар / Б.Цогтбаатар/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Я.Амаржаргал/-т даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ


081303

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 07
дугаар сарын 08-ны өдрийн А/339
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр олгох байгууллагын нэр,
чиглэл, хугацаа

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
Шинээр тусгай зөвшөөрөл олгох байгууллага			
1	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлэг	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	3 жил
2	Медипас ХХК	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	3 жил
3	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төв	Сэргээн засах тусламж үйлчилгээ	3 жил
4	Номин трейдинг ХХК	Эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох ханган нийлүүлэх	3 жил
5	Номадс вакцин ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох ханган нийлүүлэх	3 жил
6	Гэгээн хутагт ХХК	Эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	3 жил
7	Болор цитрон ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил

Эрүүл мэндийн сайдын 2019 оны
0.7 сарын 0.8 өдрийн дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СЭРГЭЭХ
БАЙГУУЛЛАГУУДЫН НЭР, ЧИГЛЭЛ

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1.	Санчир ундрах ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж ханган нийлүүлэх, импортлох
2.	Монгол Алтайн барагшуун ХХК	Биологийн идэвхт бүтээгдэхүүн үйлдвэрлэх
3.	Жи Пи Эн Эм ХХК	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх